



Анагаахын шинжлэх ухааны салбарын туйлын зорилго хүн амд үзүүлэх тусламж вйлчилгээний чанарыг сайжруулах, шинэ ололт амжилтын тусламжтайгаар шинэ технологийг нэвтрүүлж эмч, эмнэлгийн мэргэжилтэнгүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх юм. Монгол улсад анх удаа эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслын кадавр дээрх ахисан твшний сургалтыг АШУҮИС-ийн Анагаах Ухааны Сургуулийн Эх барих, эмэгтэйчүүд судлалын тэнхимийн эрхлэгч Д. Монхцэцэг, Б. Болорчимэг, Монголын эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслын нийгэмлэгийн тэргүүн Д. Оноржаргал ахлагчтай баг, Австралийн дурангийн мэс заслын нийгэмлэгийн еронхийлогч Майкл Вин Виллямс ахлагчтай баг, Францын Олон улсын дурангийн мэс заслын товийн багш Николас Бурдел, АШУҮИС-ийн Био-Анагаахын сургуулийн Эмгэг бүтэц, вйл судлалын тэнхимийн эрхлэгч Э. Баярмаа, Х.Батбаяр Эмгэг судлалын үндэсний товтэй хамтран зохион байгууллаа.

Монгол улсын хэмжээнд одоогийн байдлаар Оргоо амаржих газрын дурангийн товд эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслын чиглэлээр 49 эмч, 5 сувилагч бэлтгэгдсэн байгаа богоод үүнээс 14 эмч Франц, Австрали, Тайландад мэргэжил эзэмшсэн байна. Энэхүү Олон улсын хамтарсан сургалтаар эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслаар эмэгтэйн анатомын нарийн бүтэц судас, мэдрэлийг ялгах, хэвлийн хондийн зайг диссекци хийх, эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслын товогтэй оёдлыг тавих, зангидах техникт сургах, мэс заслын вед тохиолдох томоохон хүндрэлүүдийн вед яаралтай хийх вйлдэл, авах арга хэмжээний тактик боловсруулах, эрхтэний анатомын бүтэц, мэдрэл, судас, зонхилох тохиолдох эмэгтэйчүүдийн мэс заслын эмгэгүүдийн дурангийн тусламжтайгаар хийлээ. Мон энэ сургалт нь Монголд тодийгвй Дэлхийд сүүлийн жилүүдэд эрчимтэй хогжиж буй аргазвйг ашиглаж хийснээрээ давуу юм. Манай сургалтанд хот, ходийгийн 25 эмч

хамрагдсан богоод эдгээр эмч нар нь эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслаар торолжсон нарийн мэргэжил эзэмшсэнээр онцлог байлаа



